# МОНГОЛЫН ӨМГӨӨЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ЭЭЛЖИТ ИХ ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ БҮРТГЭХ, БАТАЛГААЖУУЛАХ ЦАХИМ СИСТЕМ АШИГЛАХ ЗААВАР

Өмгөөлөгчдийн Холбооны Их Хурал /цаашид “Их Хурал” гэх/-ын төлөөлөгчөөр бүртгүүлэх, бүртгэлийг баталгаажуулахдаа энэхүү зааврыг ашиглана.

## НЭГ. ЦАХИМ СИСТЕМД НЭВТРЭХ, БҮРТГҮҮЛЭХ

1.1.Өмгөөлөгч нь Их Хурлын төлөөлөгчөөр бүртгүүлэхдээ https://congress.ama.org.mn/ веб сайтаар орж хүсэлтээ илгээнэ.




1.2. Их Хуралд оролцох хүсэлт илгээхдээ “Нэвтэрч хүсэлт илгээх” хэсгийг дарна.



1.3. Доорх зурагт харуулсан цонхноос “Дангаар нэвтрэх” гэсэн линкийг дарж орно.




1.4. Өмгөөлөгч “Бүртгэл”-ийн системийг ашиглахаас өмнө “Төрийн танил нэвтрэлтийн Дан систем” /цаашид “Дан систем” гэнэ/-д нэвтэрнэ. Доорх цонхонд өөрийн регистрийн дугаар болон “Нууц үг”-ийг оруулан “Нэвтрэх” товчийг дарна.



1.5. “Баталгаажуулах” хэсэгт зөвхөн Бүртгэлтэй дугаараасаа “Нэг удаагийн код”-ыг 130092 дугаар луу мессежээр илгээнэ үү.




1.6. Нэгдсэн нэвтрэлтийн систем /ДАН/ цонхон дахь “Зөвшөөрөх” товчийг дарснаар Өмгөөлөгчдийн Холбооны Их Хурлын төлөөлөгчөөр бүртгүүлэх “цахим систем”-рүү шилжинэ.



1.7. Өмгөөлөгч нь “Мэдээллээ баталгаажуулах” гэсэн хэсэг дээр дарж “Миний профайл” цэс рүү шилжинэ. Та өөрийн мэдээллийг шалгаж, үнэн зөвийг хянан, холбогдох өөрчлөлт, зураг, файлыг оруулж мэдээллийг баталгаажуулан “Хадгалах” төлөвийг идэвхжүүлснээр дараагийн хэсгүүд рүү нэвтрэх боломжтой болно.

Жич: Мэдээллээ илгээсний дараа та дахин мэдээллээ засах боломжгүй болно.









1.8. “Хадгалах” төлөвийг идэвхжүүлсний дараа “Их Хуралд оролцох” цэс рүү орно. Тухайн хуудсанд таны илгээсэн хүсэлт байршсан байна.



Мөн Өмгөөллийн тухай хууль, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны дүрэм, Их Хурлын төлөөлөгчдийн нэрсийн жагсаалт үйлдэх, баталгаажуулах журмын 3 дугаар зүйлийн 3.3.1, 3.3.3-д заасны дагуу Их Хурлын төлөөлөгчөөр бүртгүүлэгч нь дараах 2 баримтыг заавал илгээсэн байх шаардлагатай.

- Гишүүнчлэлийн хураамжийн үлдэгдэлгүй тухай тодорхойлолт
- Мэргэжлийн хариуцлагын даатгалын гэрээ






## ХОЁР. ИХ ХУРАЛД ОРОЛЦОХ ТӨЛӨӨЛӨГЧИЙН БҮРТГЭЛ БАТАЛГААЖИХ ҮЕ ШАТ

2.1. Их Хурлын төлөөлөгчөөр бүртгүүлсэн гишүүн “Төлбөр төлж, баталгаажуулах” хэсэгт хандана.




2.2. “Их Хуралд оролцох” цэс рүү шилжсэний дараа Их Хурал зохион байгуулахтай холбогдон гарах зардлын нэг гишүүнд ногдох төлбөрийг төлснөөр Их Хурлын төлөөлөгчийн эрх баталгаажна.




Санал хураалт
Гарах
Эхлэл
Их хуралд оролцох
Цахим сонгууль
Миний профайл
Гарах
Мэдээллээ баталгаажуулах, хүсэлт илгээх
Төлбөр төлж, эрхээ баталгаажуулах
Их хуралд оролцох төлбөр төлөх
Төлөгч
Нэхэмжлэхийн дугаар
AMA-CONGRESS-29-951237
Төлөх дүн
1-Р АЛХАМ
Банкны аппаараа QR-ыг уншуулна уу
2-Р АЛХАМ
Гүйлгээ хийсний дараа доорх товчийг дарна уу
Төлбөрөө төлсөн — шалгуулах
Гүйлгээ банкнаас бүртгэгдэхэд хэдэн секунд зарцуулж болно. Шууд олдохгүй бол түр хүлээгээд дахин дарна уу?
QPay хуудсаар нээх
Гар утаснаас орж байгаа бол
Банкныхаа лого дээр дарж аппликейшнээ шууд нээнэ үү?
qPay wallet
Khan bank
State bank 3.0
Xac bank
Trade and Development bank
Social Pay
Most money
National investment bank
Chinggis khaan bank
Capitron bank
Bogd bank
Trans bank
M bank
Ard App
Toki App
Arig bank
Monpay
Hipay
Happy Pay
Sono
PayOn
Tino
Pass.mn
Буцах

---oOo---